



МОНГОЛ УЛС  
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2020 оны 09 сарын 17 өдөр

Дугаар А/115

Чингис хот

Газар эзэмших эрхийн гэрчилгээг  
шилжүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30.1.5, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Газрын тухай хуулийн 38 дугаар зүйлийн 38.1, 38.4 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Холбогдох хууль тогтоомжийн дагуу газар эзэмших эрхийг шилжүүлэх тухай нотлох баримтыг бүрдүүлэн гаргасан өргөдлийн дагуу иргэн Пүрэв овогтой Мөнгөнтуул эзэмшлийн Хэрлэн сумын 4 дүгээр баг /Сариг/, Тариаланчдын гудамж 406-04 тоотод байршилтай гэр бүлийн хэрэгцээний зориулалттай 170м<sup>2</sup> газрыг иргэн Пүрэв овогтой Пагмад 48 жилийн хугацаатайгаар шилжүүлэн эзэмшүүлсүгэй.

2. Иргэн Пүрэв овогтой Пагмагийн эзэмшил газрын тойм зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг иргэн П.Пагмад үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2017 оны А/18 дугаар захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ИДЭРБАТ

231010501